

"ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО"-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 03 дугаар сарын 30

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2020 оны төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын тайлантай танилцах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох статистик мэдээ, мэдээллийг ашиглан хийв.

ХОЁР. БОДЛОГЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор, эхний үе шат (2016-2020 он)-ны төлөвлөгөөг ХХАА-н сайдын 2016 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-60 дугаар тушаалаар тус тус баталсан.

Бодлогын зорилго: Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдэнэ.

Бодлогын зорилт:

Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт нэмэгдүүлэх;

Зорилт 2. Тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;

Зорилт 3. Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

Зорилт 4. Судалгаа ба хөгжлийн үйл ажиллагааг дэмжих;

Зорилт 5. Хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлэх;

Зорилт 6. Хүний нөөцийг чадавхжуулах;

Бодлогыг хэрэгжүүлэх үе шат:

✓ **I үе шат /2016-2020 он/:**

✓ **II үе шат /2021-2025 он/:**

Бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

- ❖ Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлтийг 20 хувь,
- ❖ Нийт төсөвт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийг 4 хувь,
- ❖ Нийт сүрэгт үхрийн эзлэх хувийг 10 хувь,
- ❖ Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг 200 мянган тонн,
- ❖ Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувийг 50 хувь,
- ❖ Тариалангийн эргэлтийн талбайг 1050 мянган га,
- ❖ Буудайн га-гийн ургацыг 20 центнер,
- ❖ Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшинг 100 хувь,
- ❖ Тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээлийн эзлэх хувийг 10 хувьд тус тус хүргэнэ.

ГУРАВ. БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН:

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн шалгуур үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 33.3, нийт хугацааны дундаж 48.1 хувиар тус тус үнэлэгдэв.

Хүснэгт 1

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт - 2014 он	Хүрэх түвшин - 2020 он	Хүрсэн түвшин - 2020	Үнэлгээ
1	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлт (хувиар)	12.0	15.0	11.0	-
2	Нийт төсөвт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь	2.0	3.0	2.5	50.0
3	Нийт сүрэгт үхрийн эзлэх хувь	6.7	8.0	7.1	30.8
4	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах /мянган тонн/	16.8	100.0	23.9	8.5
5	Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь	9.0	30.0	18.2	43.8
6	Эргэлтийн талбай /мянган га/	769.0	960.0	896.9	67.0

7	Буудайн га-гийн ургац /центнер/	16.9	17.3	12.6	-
8	Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин (хувиар)	54.0	70.0	44.6	-
9	Тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээлийн эзлэх хувь	0.7	5.0	7.0	100.0
Дундаж үнэлгээ					33.3

“ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТ 77.8, НИЙТ ХУГАЦААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ 68.3 ХУВЬТАЙ ТУС ТУС ҮНЭЛЭГДЛЭЭ.

Хүснэгт 2.

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Биелэлт, хувиар
1	I зорилт	17	84.7
2	II зорилт	13	83.9
3	III зорилт	18	73.3
4	IV зорилт	6	73.3
5	V зорилт	18	77.6
6	VI зорилт	8	73.8
	Нийт	80	77.8

ЗОРИЛТ ТУС БҮРИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ:

№	Зорилт	2018 он	2019 он	2020 он	Дундаж үнэлгээ
1	I зорилт	57.6	82.4	84.7	74.9
2	II зорилт	39.8	76.9	83.9	66.9
3	III зорилт	29.3	65.0	73.3	55.9
4	IV зорилт	77.5	90.0	73.3	80.3
5	V зорилт	47.1	76.7	77.6	67.1
6	VI зорилт	42.5	77.5	73.8	64.6
	Нийт	49.0	78.1	77.8	68.3

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шатны шалгуур үзүүлэлтийн хүрсэн үр дүн 48.1 хувь, төлөвлөгөөний хэрэгжилт 68.3 хувьтай үнэлэгдлээ.
2. Хөтөлбөрийн зорилтуудаас Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт нэмэгдүүлэх; (84.7%), Судалгаа ба хөгжлийн үйл ажиллагааг дэмжих; (80.3%) зорилтын хэрэгжилт 80.0 хувиас дээш үнэлэгдсэн байна.
3. Коронавирус (Covid-19)-т цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр зохион байгуулсан хэдий боловч төлөвлөсөн хурал, зөвлөгөөн, сургалт (төлөвлөгөөний 6.2.3, 7.1.5, 7.1.8)-ын арга хэмжээний хэрэгжилт 2020 онд хангалттай үнэлгээ авч чадаагүй байна.
4. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлд тусгайлсан төсөв байхгүй нь бодлогын хэрэгжилтийн үр дүнгүй байдалд нөлөөлж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. Тус бодлогын эхний үе шат 2020 онд дуусаж, хоёр дахь шат 2021 оноос эхэлж байгаатай холбоотойгоор хоёр дахь үе шатны төлөвлөгөөг 2021 оны эхний хагаст багтаан батлуулахыг Бодлого төлөвлөлтийн газарт, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд бусад төрийн захиргааны байгууллага болон гадаадын төслүүдтэй хамтран ажиллаж, бодлогын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж ажиллахыг хэрэгжилтийн газруудад зөвлөмжилж байна.

**ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ**

2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСЭЭР

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1	2.1. Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт	2.1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх;	2014 - 2020	-		<p>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар махны чиглэлийн Дорнод Монголын улаан үүлдрийн 5000 толгой, сүү-махны хосолмол ашиг шимтэй шар тарлан 5000 толгой үхрийг үзлэг, ангилалтад хамруулан биеийн галбир, зүс, сүүний гарц, махан ашиг шим болон амьдын жингийн өсөлт, хөгжилтийг судлахад түлхүү анхаарч ажиллав. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуй эрхлэгч 206 иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөлд мэргэжил арга зүйн зөвлөгөө, 12 аж ахуйн нэгжийн фермд зааварчилгаа өгөв. Нүүдэлчин ХХК өөрийн хөрөнгөөр 2020 онд Франц улсаас 96 толгой Монтебилярд гунж импортолсон. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-352 дугаар тушаалаар эрчимжсэн мал аж ахуйг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилах, бүсчлэл тогтоох, гойд ашигт шимт малын үзэсгэлэн худалдааг орон нутагт зохион байгуулах санхүүжилтийг хуваарилж аймгуудын ХХААГ-т хүргүүлэв.</p> <p>2. Малын улмын сангийн үндэсний төв нь малын үржүүлэг, биотехнологийн үйлчилгээ үзүүлдэг 32 техникчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан стандартын шаардлага хангасан махны чиглэлийн бухны 1182, хуц, ухны 1150 тун гүн хөлдөөсөн үр, 561.5 литр шингэн азотыг хөнгөлөлттэй үнээр генийн сангаас олгож иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлэв. “Түмэн шувуут” ХК Төв аймгийн Сэргэлэн суманд 250 эм хонинд, “Кайзер флашерай” ХХК Булган аймгийн Дашинчилэн суманд 300 эм хонинд тус тус махны чиглэлийн цэвэр үүлдрийн Дорпер хонины хөврөл үр суулгах ажлыг зохион байгуулав.</p> <p>3. Хонь, ямааны түүхий махны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 03 дугаар зөвлөмжөөр хонь, ямааны махны тоо хэмжээний хязгаарлалт тогтоогоогүй. Махны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд нэмэлтээр экспортлох адууны мах 15 мянган тонн, дулааны аргаар боловсруулсан хонь ямааны мах 40 мянган тонн тоо хэмжээг тогтоож, өвөлжилт хүндэрч болзошгүй 6 аймгаас 5.2 сая бог малыг эдийн засгийн оруулалтад оруулах боломж бүрдүүлсэн.</p>	90

2		2.1.2. Мал аж ахуйн салбарын хөгжил дэх төрийн зохицуулалт, дэмжлэгийн чиглэл, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үүрэг, хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох;	2014 - 2020		<p>Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үүрэг, хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох зорилгоор "Хариуцлагатай нүүдэлчин" стандарт боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын А-69 дүгээр тушаалаар байгуулж, "MNS Хариуцлагатай нүүдэлчин. Мал аж ахуйн үйлдвэрлэлд тавигдах шаардлагууд" стандартын төслийг 2020.12.28-ны өдрийн СХЗГ-ын стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болоод байна. Уг стандартыг мал, амьтны тавлаг байдлын таван эрх чөлөөг хангах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэгчийн түвшинд "Хариуцлагатай нүүдэлчин" тогтолцоог хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлага, шалгууруудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулахад хэрэглэх юм. "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам"-ыг Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Ингэснээр малчид, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгохдоо татварын цахим төлбөрийн баримтыг үндэслэн "Төсвийн урамшууллын цахим систем"-ээр урамшуулал олгох ажлыг эхлүүлсэн. ХХААХҮ-ийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр олгож байгаа дэмжлэг урамшуулал, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, татварын хуулийн хэрэгжилт хангуулах, түүхий эд бэлтгэлийн цахим тогтолцоо бий болгох зорилгоор "Хонь, тэмээний ноос, малын арьс шир бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам", "Мал төхөөрөх болон мах боловсруулах үйлдвэрийн нөөцийн мах бэлтгэхэд урамшуулал олгох журам"-ын төсөлд 2020.12.10-ны өдрийн 01/4401 тоот албан бичгээр санал авч байна. Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд "Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж дэмжигдсэн.</p>	70
3		2.1.3. Малын генетик нөөцийн бүртгэл, төлөв байдлын үнэлгээ, ашиглалт, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох, мал аж ахуй эрхлэх уламжлалт	2014 - 2020	-	<p>1. 2019 онд хийгдсэн төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан Монгол улсад өсгөн үржүүлж байгаа малын генетикийн олон янз байдал, популяцийн үүлдэрлэг байдал, тоо, газар зүйн тархалтын хувьсал, өөрчлөлт, малын генетик нөөц ашиглалт, түүний эдийн засгийн үр өгөөж, цаашдын хандлагыг бүс нутаг, аймаг, сум, дүүрэг тус бүрээр гаргаж, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж "Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайлан" сүүлийн 10 жилээр гаргав. Үндэсний тайланг 2021 онд НҮБ-ын ХХААБ-ын Генетик нөөцийн олон улсын хороонд хүргүүлэх тул тайланг ХХААХҮ-ийн Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлтгэж байна.</p>	90

		хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах;				<p>2. Малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төвтэй хамтран "Малчин өрх бүр үйлдвэрлэгч", "Малчин өрхөд үйлдвэрлэх сүү, цагаан идээ" зэрэг малчдад зориулсан гарын авлагыг боловсруулж 2400 ширхэгийг хэвлэн орон нутагт хүргүүлж, нийтийн хүртээл болгов.</p> <p>3. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нийт 1.555.178 мал, үүнээс хээлтэгч 1.506.600, хээлтүүлэгч 48578 бүртгэв. Мөн 9 үүлдрийн 21363 ямаа, 4 үүлдрийн 3604 хонь, 3 үүлдрийн 21874 үхэр, нийт 3 төрлийн 16 үүлдрийн 46814 малд удам зүйн үнэлгээ хийж, малын удам зүйн үнэлгээний программд оруулж баталгаажуулав.</p> <p>5. "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программын туршилтыг Өвөрхангай аймгийн ХХААГ, сумдын ХААТ, МҮТН, төсөлд сонгогдсон Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумын малчдыг хамруулан зохион байгуулж, 173.2 мянган малыг бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг оруулах туршилтыг амжилттай зохион байгуулав.</p>	
4		2.1.4. Малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх;	2014 - 2020	430.0 сая төгрөг /Улсын төсөв/		<p>1. Мал аж ахуйн салбарт 2020-2030 онд хэрэгжүүлэх "Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги"-ийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-15 дугаар тушаалаар баталгаажуулав. Уг стратегид малын төрөл, ашиг шимийн чиглэлээр үржүүлэх бүс байршлыг тодорхойлж, селекцийн үр ашиг, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөлт, тоо толгойн өөрчлөлт, сүргийн эргэлтийг 10 жилээр тооцож, 2 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>2. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-112 дугаар тушаалын хүрээнд улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр үржлийн малд үзлэг, ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг 21 аймгийн 99 сумын 94966 бод, 131550 бог, нийт 226516 малыг технологийн хугацаанд 59 мал үржүүлэг технологийн нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэв.</p> <p>3. Орон нутгийн цөм сүргийн салбар нэгжийн малаас нийт жишигт тэнцсэн 241 хээлтүүлэгчийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд худалдан борлуулж, 297 толгой өсвөр хээлтүүлэгчийг үржилд зориулан сонгон тавив.</p> <p>4. АХБ-ны зээлийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймгийн Богд, Жинст, Өлзийт, Эрдэнэцогт, Баян-Овоо суманд "Цаг агаарын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн хөгжил" төслийг хэрэгжүүлэхээр болов.</p>	70
5		2.1.5. Мал, амьтны үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, зах зээлийн эрэлт	2014 - 2020	-		<p>1. "Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам"-ын хүрээнд 2020 онд 4 аймгийн 4 суманд үржүүлж буй нутгийн шилмэл малд явуулсан үржил, селекцийн ажилд хянан магадлагаа хийж, ажлын тайлан, дүгнэлтийг Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хороо, ХХААХҮ-ийн</p>	90

		хэрэгцээнд нийцүүлэн явуулж, бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийг бий болгон, генийн санг хамгаалах болон малын нөхөн үржүүлгийг сайжруулахад био технологийн ололтыг ашиглах, малын үржүүлэг, технологийн орон нутгийн нэгжүүдийг чадавхжуулах;			Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бие даасан үүлдрийн хэсэг, омгоор баталгаажуулж, 2020-2025 он хүртэл хэрэгжүүлэх үржил селекцийн ажлын хөтөлбөрийг батлав. Үүний үр дүнд Монгол Улсад баталгаажсан үүлдэр, омгийн мал 56 болсон бөгөөд шинээр баталгаажсан үүлдэрт 10 жил, үүлдрийн болон үржлийн хэсэг, омгийн малд 5 жилийн үржил селекцийн ажлын хөтөлбөрийг баталж, цаашдын чиглэлийг тодорхойлон ажиллаж байна. 2. Малын генийн санг хамгаалах, баяжуулах ажлын хүрээнд нийт 12800 тун стандартын шаардлага хангасан үр үйлдвэрлэв. 3. Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх ажлыг 21 аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан бөгөөд одоогийн байдлаар нийт 202.0 мянган хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлснээс Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний 77 нэгжид 6.8 мянган хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлээд байна. 4. Гойд ашиг шимт мал шалгаруулах журмыг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-346, Сайжруулагч малыг үржилд тохируулан сонгох, цөм сүрэг бүрдүүлэх технологийн журмыг ХХААХҮ-ийн сайдын А-336 дугаар тушаалаар тус тус баталгаажуулав. 5. Гойд ашиг шимт малын улсын бүртгэлийн гэрчилгээ, цөм сүрэг бүхий өрхийн батламж, үржлийн хээлтүүлэгч малын гэрчилгээ зэрэг 9 төрлийн гэрчилгээний загварыг боловсруулж "Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээнд дэмжлэг үзүүлэх нь" ТСП/MON/3707 техник хамтын ажиллагааны төслийн хүрээнд 55.0 мянган ширхэг гэрчилгээ хэвлүүлэн аймаг, нийслэлийн ХХААГ-г хуваарилан хүргүүлэв.	
6		2.1.6. Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, эрүүлжүүлэх стратегийг бүсчлэн хэрэгжүүлэх, халдварт өвчний тохиолдлыг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах, халдварт өвчингүй тайван байдлыг	2014 - 2020		МЭЕГ-ын даргын 2019 оны А/84, А/85 дугаар тушаалаар Монгол улсын газар нутгийг 3 бүсчлэлд хувааж мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. Монгол улсын баруун бүсийн аймгуудыг шүлхий өвчнөөс эрүүл статусыг ДМАЭМБ-аас авах тухай хүсэлт/dossier/-ийг англи хэлээр бэлтгэн ДМАЭМБ-д 2020 онд цахимаар хүргүүлсэн байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан "Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам"-ын дагуу гаргасан Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газрын "Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн мал сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз, адууны ям өвчингүй, тайван байдал"-ыг тогтоолгох хүсэлтээр МЭЕГ-ын даргын 2019 оны А/76, А/155 дугаар тушаалаар шинжээчийн баг томилон эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг МЭЕГ-ын дэргэдэх Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, МЭЕГ-ын даргын 2019 оны А/256 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн үхэр сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван	90

		тодорхой бүс нутгаар баталгаажуулах;			бүс”, Дархан-Уул аймгийн үхэр сүргийг “Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван бүс”-ээр тус тус тогтоон зарласан. Улаанбаатар хотын 3,0 мянган үхэрт сүрьеэ өвчний тандалтыг хийж, үр дүнг нэгтгээд байна. 2020 онд Монгол улсын хэмжээнд үхрийн сүрьеэ, лейкоз өвчнийг тандах ажлыг хийж, цаашид бүсчилсэн байдлаар эрүүлийг баталгаажуулах ажлыг төлөвлөн ажиллаж байна. Адууны ям, халдварт цус багадах өвчнийг улсын хэмжээнд төлөвлөгөөт шинжилгээг хийж байна. 2019 онд Улаанбаатар хот орчмын үхэр бүрэгт бруцеллёзын эрүүлийг баталгаажуулах шинжилгээг 34,0 мянган үхэрт хийж, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2020 онд хэлэлцүүлэн "Бруцеллёзоос эрүүл сүрэгтэн" гэрчилгээг 14 аж ахуйн нэгжид олгоод байна.	
7		2.1.7. Олон улсын жишиг, шаардлагад нийцсэн мал эмнэлгийн албаны үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог сумын түвшин хүртэлх бүх шатанд бүрдүүлэх, орон нутгийн мал эмнэлгийг чадавхжуулж, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх;	2014 - 2020		Улсын Их Хурлын 2018 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газар гэсэн хэсгийн Мал эмнэлэг, үржлийн газар” гэснийг “Мал эмнэлгийн ерөнхий газар” гэж өөрчилсөн. Засгийн Газрын 2018 оны 186 дугаар тогтоол гарсантай уялдан ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А/115 дугаар тушаалаар Мал эмнэлгийн ерөнхий газрын бүтэц орон тоог 4 газар, 44 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулахаар тусгагдан бүтэц, зохион байгуулалт хийж, үйл ажиллагаагаа явуулж байна. 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори УТҮГ, Биокомбинат УТҮГ, МЭЭСБУЛ УТҮГ-ыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн хүрээнд Архангай аймгийн Их-Тамир, Өндөр-Улаан, Баянхонгор аймгийн Баянцагаан, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Сантмаргац, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Цэцэрлэг, Ховд аймгийн Мөнххайрхан, Чандмань, Дарви, Төв аймгийн Сүмбэр суманд Мал эмнэлгийн ерөнхий газар /Ногоон алт/ аас 160,0 сая, орон нутгийн төсвөөс 93,5 сая, хувь хүнээс 47,5 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэж, Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэснээс бүрэн ашиглалтад орсон Завхан аймгийн Сантмаргац, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Архангай аймгийн Өндөр-Улаан сум байна. Үлдсэн 7 сумын барилга угсралтын ажил үргэлжилж, дунджаар 70%-ийн гүйцэтгэлтэй байна.	90

8		2.1.8. Мал эмнэлгийн үйлчилгээнд зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх;	2014 - 2020		<p>Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагааны MNS 5368:2018 стандартад Мал эмнэлгийн тусгай мэргэшлийн тусламж, үйлчилгээний нэгж нь дараах чиглэлээр дагнасан болон хосолсон үйлчилгээ эрхэлж болно гэж тусгасан байна. Үүнд: - Биологийн хог хаягдал, сэг зэм устгал, - Эвэр, туурайн засал, гоо зүйн үйлчилгээ, - Тусгай мэс ажилбар, - Уламжлалт мал эмнэлэг, - Лабораторийн шинжилгээ, - Ариутгал, халдваргүйтгэл, - Мал угаалга гэх мэт</p> <p>Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын дагуу мал эмнэлгийн ажил, үйлчилгээний нэр төрлийг дээрх байдлаар шинэчлэн төрөлжүүлж байна. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ажлын байр, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалт, бэлэн байдалд батлагдсан шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгөх ерөнхий болон төрөлжсөн, тусгай мэргэшлийн чиглэлээр 78 асуулга бүхий асуумж боловсруулан мал эмнэлгийн нэгдсэн системд байршуулж, мал эмнэлгийн үйл ажиллагааны чадамжийг үнэлэх ажлыг зохион байгуулсан.</p>	90
9		2.1.9. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлснээс бусад бэлчээрийг төрийн эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалттайгаар ашиглуулах, эрчимжсэн мал аж ахуйд тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулах;	2014 - 2020	-	<p>1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд тэжээл тариалах зориулалтаар газар ашиглуулах талаар санаачлага гарган ажиллах талаар ХХААХҮ-ийн сайдын баталсан удирдамжийг аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудад хүргүүлсэн. Уг удирдамжийн дагуу Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр, Хэнтий аймгууд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ИТХ-ын тогтоолоор батлуулан ажиллаж байна. Энэ ажлын үр дүнд 2020 онд хураан авсан таримал тэжээлийн хэмжээ өмнөх оныхоос 61.0 мянган тонн буюу 50.3 хувиар нэмэгдсэн.</p> <p>2. Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхлэх стратегийн бүс нутаг болгохтой холбогдуулан ХХААХҮЯ-ны ТНБД-ын тушаалаар “Тариалангийн бүсээс уламжлалт мал аж ахуйг шилжүүлэх, ЭМАА, газар тариалан эрхлэх төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах” ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн 17 сумын 56 баг, Дархан-Уул аймгийн 4 сумын 14 багийн нутгийг тариалангийн бүс болгон чөлөөлөх, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийг нүүлгэн шилжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын удирдамжийг орон нутагт хүргүүлэв. Цаашид Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд бэлчээр, хадлангийн газар, таримал тэжээл тариалах тариалангийн талбайг гэрээгээр ашиглуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.</p>	70

10		2.1.10. Бэлчээр болон байгалийн бусад нөөцийн зохистой ашиглалт, бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх;	2014 - 2020	-	<p>1. "Монгол мал" үндэсний хөтөлбөрт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг улс, аймаг, сумын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтад авч цаг хүндэрсэн үед ашиглахаар заасан ажлыг эрчимжүүлэх зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-153 дугаар тушаалаар орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хүрээнд Архангай 178.0, Дундговь 205.6, Дорнод 299.9, Өвөрхангай 496.5, Өмнөговь 3030.0, Сүхбаатар 629.8, Хөвсгөл 245.6, Ховд 102.3, нийт 5187.7 мян га бэлчээрийг орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээр болгосон байна. Отрын бэлчээрийн хил заагийг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах ажлыг аймгуудын Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хийж байна.</p> <p>2. Швейцарийн хөгжлийн агентлагийн Малын эрүүл мэнд-Ногоон алт төсөлтэй хамтран бэлчээр ашиглалтын журмыг сумдын ИТХ-аар батлуулах, ХЗДХЯ-нд бүртгүүлэхэд шаардлагатай мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэн, бодлогын чиглэл өгч ажиллав. Энэ ажлын хүрээнд 2020 оны байдлаар улсын хэмжээнд өссөн дүнгээр 13 аймаг, 42 суманд бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын төслийг баталгаажуулаад байна. Үүнээс Захиргааны хэм, хэмжээний актын улсын бүртгэлд 2020 оны байдлаар нийт 8 аймгийн 19 сумын “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг бүртгүүлсэн байна. Эдгээр журмын 13 нь 2020 онд шинээр бүртгэгдсэн байна.</p>	90
11		2.1.11. Бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл, сүргийн бүтцийг тохируулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох, бэлчээрийг оновчтой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;	2014 - 2020	-	<p>1. УИХ 2020 оны 11 дугаар сарын 13-ны өдөр Малын тоо, толгойн албан татварын тухай хуулийг батлан гаргасан. Энэхүү хуулиар бүх малаас малын төрөл тус бүрт 0-2000 төгрөгийн татвар ногдуулах бөгөөд татварын орлогыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн, зарцуулахаар тусгасан.</p> <p>2. ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд, ҮСХ-ны дарга нарын хамтарсан 2019 оны А/113, А-250, А/422 дугаар тушаалаар “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал”-ыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2020 оны 09, 10 дугаар сард Архангай, Дундговь, Дорнод, Ховд аймагт бүсчлэн зохион байгуулсан “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах нь” зөвлөгөөнд оролцогч 570 гаруй мэргэжилтэнд “Эко системийн судалгааны төв”-өөс “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал”-ын сургалт хийсэн. Мөн Мерси кор ОУБ-тай хамтран Ховд аймагт Баян-Өлгий, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгийн ХХААГ-ын бэлчээрийн асуудал хариуцсан 150 гаруй мэргэжилтэнд бэлчээр ашиглалт, малын чанарыг сайжруулах сургалт зохион байгуулж, мал сүргийн эргэлтийг зөв хийж малын тоог бэлчээрийн даацад тохируулж бууруулах боломжийн талаар ХААИС-тай хамтран сургалт зохион байгуулав.</p>	90

					<p>3. АДОБАЗ нь Дорнод аймгийн Чойбалсан, Өвөрхангай аймгийн Хөхдэл аймаг дундын отрын бүс нутгуудад төлөв байдлын үнэлгээ, бэлчээрийн даацын судалгаа хийлгэх зорилгоор “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж дүгнэлт гаргуулсан. Дүгнэлт, судалгаанд үндэслэн дээрх 2 аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээрийг ашиглах, хамгаалах менежментийн төлөвлөгөө батлуулаад байна.</p> <p>4. Засгийн газрын 19-р тогтоолд мал, махны экспортыг бүх хэлбэрээр дэмжих бодлогын зорилт дэвшүүлэн, холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгснөөр аймгуудаас мал нядлах, мах бэлтгэх арга хэмжээг өргөн хүрээтэй зохион байгуулж 2020 онд 24.8 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулав. Үүний дүнд 2020 оны жилийн эцсийн мал тооллогоор нийт 67.1 сая тоологдож өмнөх оноос 3.9 сая малаар /5.5 хувиар/ буурлаа.</p>	
12	2.1.12. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэргэч амьтан, шавжтай тэмцэх арга хэмжээг байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан өргөжүүлэх;	2014 - 2020	-	<p>1. Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг микробиологийн болон энгийн механик биологийн аргаар 2020 онд нийт 17 аймгийн 184 сум, 4 аймаг дундын отрын бүс нутгийн 1.63 сая га бэлчээрийн талбай хамруулсан нь эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан нийт тэмцэх шаардлагатай талбайн 15.47 хувьтай тэнцсэн. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын 2020 оны гүйцэтгэл нь өмнөх оноос 600 мянган га, сүүлийн 10 жилийн дунджаас 1.0 сая га талбайгаар тус тус нэмэгдсэн.</p> <p>2. Царцаатай химийн аргаар тэмцэх арга хэмжээг 2020 онд Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймгийн нийт 20 сумын 66 мянган га талбайд холбогдох стандартыг баримтлан дунджаар 82 хувийн үр дүнтэй гүйцэтгэлээ. Ингэснээр бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг нийт 20 аймгийн 204 сумын 2.29 сая га талбай хамруулж, мал аж ахуйн үйлдвэрлэлд хэвийн ашиглах боломж бүрдүүлсэн.</p> <p>3. Аймаг дундын отрын бүсийн захиргааны даргын 2020 оны “Аймаг дундын отрын бүс нутагт үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” А-13 дугаар тушаалаар аймаг дундын отрын бүс нутгуудад нийт 64.375 мян.га талбайд үлийн цагаан оготно устгах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Хэнтий аймаг дахь Хэрлэнбаян-Улааны отрын бүс 29,4 мян.га; 2. Булган аймаг дах Чилэн отрын бүс 10.0 мян.га; 3. Говьсүмбэр аймаг дах Малахын отрын бүс 15.0 мян.га; 4. Өвөрхангай аймаг дахь Хөхдэлийн отрын бүс 10.0 мян.га;</p>	100	
13	2.1.13. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим	2014 - 2020	1.67 тэрбум төгрөг /Улсын төсөв/, 3.7 тэрбум төгрөг /	2020 онд Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 193 суманд улсын төсвийн 1.67 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83, гадаадын төсөл, хөтөлбөрийн 3.7 тэрбум төгрөгөөр 180, орон нутгийн төсвийн 3.7 тэрбум төгрөгөөр 287 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачилгаар 170 гар худаг, нийт 9.0 тэрбум төгрөгөөр 550 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 825.0 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамж нэмэгдүүлсэн. Орон	100	

		хүч ашиглах малчид, иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих;		орон нутгийн төсөв/, 3.7 тэрбум төгрөг /ОУ-ын төсөл, хөтөлбөр/	нутаг, төсөл хөтөлбөрийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 15 аймагт 184 худаг сэргээн засварлах, 11 аймагт 126 булаг тохижуулах, 5 аймагт 9 хөв цөөрөм, Өвөрхангай аймагт 2 худаг шинээр гаргаж, сэргээгдэх эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулж ашиглалтад оруулсан.	
14		2.1.14. Малын тэжээл, био бордоо, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тэдгээрт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, нутагшуулах;	2014 - 2020	-	<p>1. 2020.12.04-2021.07.01-ний хооронд бүх төрлийн тэжээлийн үрийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг тэглэж, аж ахуй нэгжүүдийн тэжээлийн ургамлын үр импортлох боломж бүрдүүлсэн.</p> <p>2. 2020 онд аж ахуй нэгж, иргэд 55.4 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалж, 32.9 мянган тн шүүст тэжээл бэлтгэсэн байна.</p> <p>3. УБ-т 5000 тонн бүрэн найрлагат хорголжин, багсармал бүх төрлийн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат тэжээлийн үйлдвэр шинээр ашиглалтад орсон. Бүрэн автомат үйлдвэр нь дотроо нэмэлтээр премиксийн үйлдвэр, тос шахах үйлдвэр, өвс бутлах, хорголжлох үйлдвэртэй.</p> <p>4. Дархан Уул аймгийн ХХААГ нь газар тариалан төмс, хүнсний ногооны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тогтворжуулах, хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор “Бордоо” төслийн хүрээнд “Гарааны био ундарга” ХХК-ийн “Ризо” шингэн бордооны үйлдвэр байгуулах ажилд 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Ризобактерийн шингэн бордоог сурталчлах ажлыг 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 480 гаруй өрхийн тариалан эрхлэгч хамруулав.</p> <p>5. Говь-Алтай аймгийн Бугат, Шарга, Дэлгэр суманд хэрэгжүүлж буй "Гамшигт тэсвэртэй орон нутаг" төслийн хүрээнд малчдын бүлгийг тэжээл тариалах чадавхид сургах, тэжээлийн ургамал тариалах зорилгоор бага оврын техник нийлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Шинэ хөдөө Дорноговь төслийн 83,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 суманд хадлангийн бага оврын техник, тоног төхөөрөмж олгосон. Дорнод аймаг тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сангаас 20,0 сая төгрөгийн дэмжлэгийг 1 иргэнд, Орхон аймаг 20,0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлийг 2 иргэнд олгосон.</p>	70

15	2.1.15. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр, цехийг бүсчилж хөгжүүлэх;	2014 - 2020			<p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэрийг бүсчилж хөгжүүлэх зорилгоор: 1. "Дархан арьс ширний цогцолбор" төслийг хэрэгжүүлж дэд бүтцийн бүтээн байгуулалтыг 2019 оноос хийж эхэлж, 14 барилга, байгууламжийн ажил хийгдэхээс 6 ажил хийгдэж 22.9%-тай (36.63 тэрбум төгрөг) байна.</p> <p>2. Баруун бүсийн мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах зорилготой Шинэ Ховд УТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг 2018 оноос эхлүүлж бүтээн байгуулалт 90 гаруй хувьтай байна. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих, технологийн шинэчлэл хийх” төслийг Ховд аймгийн Дарви сум, Баянхонгор, Архангай, Сүхбаатар аймагт байгуулахаар газрын байршлыг сонгоод байна.</p>	90
16	2.1.16. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түүний чанар, аюулгүй байдалтай уялдуулах;	2014 - 2020			<p>Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түүний чанар, аюулгүй байдалтай уялдуулах ажлын хүрээнд:</p> <p>1. ХХААХҮ-ийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал олгох журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.</p> <p>2. ХХААХҮ-ийн салбарын урамшууллын нэгдсэн программ бий болгов.</p> <p>3. Арьс шир, ноос, ноолуур, сүү, мах зэрэг малын гаралтай түүхий эдэд урамшуулал олгон малчдын орлогыг нэмэгдүүлж байна.</p> <p>Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох” журмыг батлуулсан. 11 дүгээр сарын 01-нээс 30-ны хооронд 1,939,944.0 литр түүхий сүү нийлүүлсэн 2375 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 969,972,000.0 төгрөгийн урамшуулал олгосон.</p>	100
17	2.1.17. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн бага ашиглалттай байгаа нөөцийн (дотор мах, дайвар бүтээгдэхүүн, хонь, ямаа, ингэний сүү гэх мэт) боловсруулалтыг нэмэгдүүлэх.	2014 - 2020			<p>Ингэний сүү боловсруулах үйлдвэрийн байршил, газар, дэд бүтцийг шийдвэрлүүлж, үйлдвэрийн зураг төсвийн ТЭЗҮ-ийг "Монгол тэмээ корпораци" ХХК-иар орон нутгийн төсвөөр гүйцэтгүүлсэн. 2020 оноос үйлдвэрлэл ашиглалтад орж, ингэний сүүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн.</p>	50
ЗОРИЛТ 2.1						84.71

18	3.1. Тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт	3.1.1. Тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж, үр ашигтай ашиглах, бүртгэл, хяналтыг сайжруулах, тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжсэн мал аж ахуйтай хослон хөгжүүлж, тэдгээрийг эрхлэх бүс нутгийг тогтоох;	2014 - 2020		Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Тариалангийн бүс нутаг, түүний заагийг тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг харгалзан тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Булган, Архангай, Өвөрхангай, Хэнтий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн эхний ээлжинд дээрх 7 аймгийн материалыг эцэслэн боловсруулж Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Бүс нутаг тогтоолгох асуудлаар Хөвсгөл, Увс аймгаас материал ирсэн боловч бүрдэл дутуу гэдэг шалтгаанаар буцаагдсан болно. Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг зохистойгоор хослон эрхлэх боломжийг бүрдүүлэх, орон нутгийн Төрийн захиргааны байгууллагууд болон мэргэжлийн Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулж Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 05 дугаар сард 02 тоот албан даалгаврыг гаргуулан орон нутагт хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулж байна.	100
19		3.1.2. Төвийн бүсэд тариалангийн газрын боломжит орон зайн ашиглалтыг сайжруулах, баруун, зүүн бүсэд атаршсан газрыг эргэлтэд оруулах;	2014 - 2020		Дархан-Уул, Төв, Хэнтий, Булган, Говь-Алтай, Завхан аймагт 2016 оноос хойш нийт 42.0 мянган га атаршсан талбай эргэлтэд тус тус оруулаад байна. Сүхбаатар аймаг, Увс аймгийн Баруунтуруун суманд тус бүр 10 мянган тонн элеваторыг Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын хөнгөлөлттэй зээлээр байгуулахаар 2020 онд элеваторын зураг төслийг хийгээд байна.	90
20		3.1.3. Хөрс боловсруулах тэг элдэншүүлгийн технологийг үйлдвэрлэлд үе шаттайгаар бүрэн нэвтрүүлэх болон тариалангийн газрын хөрсийг салхи, усны элэгдэл, эвдрэлээс хамгаалах	2014 - 2020		Үр тарианы үйлдвэрлэлд цомхотгосон ба тэг элдэншүүлгийн технологийг мөрдөн ажиллаж 360.0 мянган га талбайд нэвтрүүлээд байгаагаас энэ онд 196.0 мянган га-д дэвшилтэд технологиор уринш боловсруулж бэлтгэсэн дүнтэй байна. Атар хөрсийг анх боловсруулах болон атаршсан хөрсийг дахин эргэлтэнд оруулахаас бусад тохиолдолд хөрсийг хөмрүүлж хагалахыг хориглосон. Төмс, хүнсний ногоо, хүлэмжид хөрсийг хөмрүүлж хагалах технологитой. Хөрс боловсруулах, үрлэх ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэх хийн үрлүүр, химийн уриншийн зориулалттай гербицид цацах машин, олон үйлдэлт сийрүүлүүр, сүрэл цацах төхөөрөмжтэй үр тариа хураах өнөдөр хүчин чадлын комбайн, тракторыг дилер аж ахуйн нэгжүүд нийлүүлж байна. Нийт уриншийн 45 хувийг тэг элдэншүүлгийн	100

		нөхцөлийг бүрдүүлэх;			<p>технологоор болосруулсан. Хураалтын ажил 100 хувь сүрлэн хучлага цацаж байгаа. Үр тариа үрлэх ажлын 70 хувийг хийн үрлүүрээр гүйцэтгэж байна. Тариалангийн хөрсийг салхины элэгдлээс хамгаалах сүрлэн хучлагыг мал амьтны хөлөөс хамгаалах зориулалтаар тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, усны зарцуулалт багатай усалгааны тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд төрөөс хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авч байна.</p> <p>Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг мал амьтан, салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаас ирүүлсэн саналыг үндэслэн 2018-2019 онуудад улсын төсвийн 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул, Дорнод, Хөвсгөл аймгийн тариалангийн бүсэд нийт 854.4 км хашаа барьж байгуулсан бөгөөд хашаанд нийт 460 гаруй иргэн аж ахуйн нэгжийн 101.5 мянган га талбай хамрагдаад байна. Энэ онд гэрээний дагуу тариалангийн талбайд байгуулсан зарим хашааг хүлээн авч орон нутгийн өмчлөлд шилжүүлж, тариалангийн талбайн хөрсийг хамгаалах, хашаа эзэмшүүлэх гэрээ байгуулав.</p>	
21		3.1.4. Таримлын сэлгээний ээлжийн тоог нэмэгдүүлж, цулгүй уриншийн хэмжээг бууруулах, эрчимжсэн мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн түүхий эдийн хангамж, гадаад зах зээлийн хэрэгцээнд тулгуурлан таримлын зохистой сэлгээг мөрдөж, сэлгээнд тариалсан ашигт таримлыг зах зээлд нийлүүлэхийг дэмжих;	2014 - 2020		<p>Сэлгээний таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, үрийн нөөц бүрдүүлэх тухай” асуудлаар Сайдын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулга хийж, 02 тоот зөвлөмж гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү зөвлөмжөөр Сэлгээний таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, үрийн нөөц бүрдүүлэх асуудлыг 2020 оны үйл ажиллагаанд загвар төсөл болгон тусгаж үе шаттайгаар хэрэгжүүлэх, таримлын сэлгээг татварын бодлогоор дэмжих асуудлыг цогцоор авч үзэхийг зөвлөсөн болно. Тиймээс энэ хаврын тариалалтад шаардлагатай байгаа Хошуу будаа болон тэжээлийн арвайн үр тус бүр 200 тонн, Рапсын хар үр 350 тонн, Эрдэнэшишийн үр 20 тонн, вандуйны үр 30 тонн, шар будааны үр 10 тонныг тус тус импортоор нийлүүлэх ажлыг технологийн хугацаанд багтаан шуурхай зохион байгуулж, хамтран ажиллах тухай үүргийг ХААДС-д хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулан ажилласнаар тосны ургамлын үр 150 тонныг нийлүүлэхээр Майнд тэйч ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж дамжуулан зээлдүүлэх аргаар нийлүүлэх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн импортоор тэжээлийн таримлын үр нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласнаар 300 тонн хошуу будаа, 50 тонн арвай, 10 тонн эрдэнэ шишийн үрийг аж ахуйн нэгжүүдэд зуучилан тариалах боломжийг бүрдүүлж ажиллав. Ургац хураалтын дүнгээр нийтдээ 428.9 мянган тонн үр тариа, үүнээс 408.1 мянган тонн улаанбуудай, 240.5 мянган тонн төмс, 113.5 мянган тонн хүнсний ногоо, 21.2 мянган тонн тосны ургамал, 169.4 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд 238.6 мянган тонн буудай нийлүүлэгдээд байна. Үүнийг</p>	70

					өнгөрсөн оны ургацын дүнтэй харьцуулахад үр тариа 4.1 мянган тонноор, төмс 49.7 мянган тонноор, хүнсний ногоо 18.9 мянган тонноор, тэжээлийн ургамал 49.8 мянган тонноор тус тус ахиу байна.	
50		5.1.2. Нээлттэй лабораторид суурилсан био, нано технологийг хөгжүүлж оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх;	2014 - 2020			ХХААХҮ-ийн Сайдын 2017 оны А-36 дугаар тушаалаар баталсан “Салбарын судалгаа, хөгжлийн ажилд грант олгох журам”-ын дагуу Сайдын зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Сайдын нэрэмжит грант горилж дэвшсэн бүтээлүүдийг батламжилсан. Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн эдийн засаг, техникийн чиглэлийн бүтээлүүдийг шинжлэх ухааны багтаамж буюу технологийн түвшин, техник эдийн засгийн үзүүлэлт, зах зээлийн эргэлтэд орох чадамжийн түвшин буюу үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах бодит боломж, ижил төстэй технологи, бүтээгдэхүүн үйлчилгээнээс давуу тал, өрсөлдөх чадвар, нэмүү өртөг бий болгож буй түвшин зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан байдлаар нь үнэлгээ өгч шалгаруулсан. Сайдын “Судалгааны ажилд инновацийн грант олгох тухай” 2020 оны А-231 дүгээр тушаалаар дараахь 5 бүтээлийн багт Сайдын нэрэмжит грантыг олгосон. 1. УГТХ-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, Н.Баярсүх удирдагчтай “Вандуйн баялаг сорт” сэдэвт бүтээл; 2. ШУТИС-ийн ҮТС-ийн салбарын профессор, доктор (Sc.D), Л.Удвал удирдагчтай “Хүүхдийн гутлын дизайн, технологи боловсруулалт” сэдэвт бүтээл; 3. МЭХ-ийн Молекул генетикийн лабораторийн Эрдэм шинжилгээний дэд ажилтан, доктор (Ph.D), Д.Даваасүрэн удирдагчтай “Адууны нийлүүлгийн өвчний түргэвчилсэн оношлуур” сэдэвт бүтээл; 4. ШУТИС-ийн ҮТС-ийн Хүнс, судлалын эрдэм шинжилгээний төвийн эрхлэгч, доктор (Ph.D), Г.Төрмөнх удирдагчтай “Хүнсний бүтээгдэхүүнийг бичил шим тэжээл био-иодоор баяжуулах судалгаа-үйлдвэрлэлийн дүн” сэдэвт бүтээл; 5. УГТХ-ийн лабораторийн эрхлэгч, доктор (Ph.D), О.Нинжмаа удирдагчтай “Төмсний дахин боловсруулалтын Атар-1 сорт” сэдэвт бүтээл; тус тус болно. Дээрх 5 бүтээлийн багт Сайдын нэрэмжит грантын “Батламж”, 5.000.000 төгрөгийн грантыг гардуулав.	90
51		5.1.3. Шинжлэх ухаанд суурилсан ногоон үйлдвэрлэл, бизнес, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх;	2014 - 2020			“Даян Дэлхийн ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн өв нутгийг судлах, бүртгэх, зарлах, хамгаалах санаачлага”-ын хамрах хүрээг өргөжүүлэх, төв Азийн эх газрын эрс тэс уур амьсгалтай, хуурай сэрүүн бүсэд мал аж ахуй, жижиг тариалан эрхлэх, өрхийн технологиор хүнсний үнэт чанар бүхий бүтээгдэхүүн боловсруулах үнэлж баршгүй арвин арга туршлага хуримтлуулсан, үеэс үед уламжлан хадгалж ирсэн өв уламжлалыг НҮБ-ын ХХААБ-д бүртгүүлэх чиглэлээр орон нутагт ажиллаж, өв нутгаар нэр	70

					дэвшүүлэх хэд хэдэн нутгийн товч танилцуулга, урьдчилсан тодорхойлолт гаргасан болно.	
52		5.1.4. Шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн технологийн инкубатор, загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх;	2014 - 2020		“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” Төрийн өмчит аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газрыг улсын төсөвт үйлдвэрийн газар болгон, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” Төрийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газартай нэгтгэн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв” Төрийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах Засгийн газрын 2020 оны 93 тогтоолыг баталсан. “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” нь хөнгөн үйлдвэрийн чиглэлээр тэр тусмаа арьс ширний чиглэлээр, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” нь хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр судалгаа-туршилт-нэвтрүүлэлт-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тус тусдаа хэрэгжүүлдэг байсан бол “Судалгаа хөгжлийн төв” болгон 2 байгууллагыг нэгтгэн, өөрчлөн зохион байгуулснаар салбарын хэмжээнд нэгдсэн удирдлага, бүтэц зохион байгуулалттайгаар Судалгаа-туршилт-нэвтрүүлэлт-үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой.	70
53		5.1.5. Салбарын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны материаллаг орчныг бэхжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орны зээл тусламжийн хөрөнгийг нэмэгдүүлэх;	2014 - 2020		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн Арьс ширний шинжилгээний лаборатори нь “Сорилтын болон баталгаажуулалтын лабораторид тавигдах ерөнхий шаардлага” MNS ISO 17025 стандартын шаардлагыг ханган, итгэмжлэгдсэн лабораториор ажиллаж байгаа бөгөөд 2020 оноос “Сорилтын болон баталгаажуулалтын лабораторид тавигдах ерөнхий шаардлага” MNS ISO 17025: 2018 шинэ стандартын шаардлагын дагуу “Чанарын гарын авлага”-ын 7 дахь хувилбарыг боловсруулан мөрдүүлж, итгэмжлэлийн хүрээг гутлын шинжилгээгээр өргөтгөн ажиллаж байна. НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага ЮНИДО-гийн тусламжтайгаар Судалгаа хөгжлийн төвд "Аж үйлдвэрлэлийн ирээдүй" танхим тохижуулан хүлээлгэн өгсөн. Мөн цахим сургалтын 6 хөтөлбөрийн дагуу мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах зэрэг ажлыг хамтран хэрэгжүүлсэн.	70
54		5.1.6. Олон улсын жишигт хүрсэн түвшний судалгааны нарийвчилсан арга,	2014 - 2020		21 аймгийн ХХААГ-ын экстейншны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг БНЭУ-д туршлага судлах, сургах зорилгоор сургалтад хамруулахаар тохиролцон эхний ээлжийн бүрэлдэхүүнийг явуулах бэлтгэл хангагдсан үед Ковид цар тахлын тохиолдол Монгол Улсад	70

		технологийг эзэмшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх, салбарын чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих.				бүртгэгдсэнтэй холбоотойгоор хил хаагдаж, энэхүү ажил зогсонги хүлээлтийн байдалд орсон.		
ЗОРИЛТ 5.1							73.33	
55		6.1.1. Улсын төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг улсын төсвийн 3-4 хувьд хүргэх;	2014 - 2020			Улсын төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг улсын төсвийн 2.5 хувийг эзэлж байна.	70	
56	6.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулах, худалдааг хөнгөвчлөх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:	6.1.2. Орон нутгийн төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг хоёр дахин нэмэгдүүлэх;	2014 - 2020			Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний орон нутгийн санхүүжилттэй малын эм, вакцин, үйлчилгээний хөлсөнд 6,7 тэрбум төгрөгийг 2020 оны төсөвт тусгуулсан. Мөн салбарт хэрэгжиж буй "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл"-өөс орон нутагт хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтад тухайн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нийт хөрөнгө оруулалтын 70 хувийг төслөөс, 30 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр аймаг тус бүртэй гэрээ байгуулан ажилласан. Тус арга хэмжээнд нийт 6 аймагт 43 арга хэмжээг 7.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн. Үүнд: Архангай аймагт 1.4 тэрбум төгрөгөөр 6 арга хэмжээ, орон нутгаас 420.0 сая төгрөг, Өвөрхангай аймагт 1.5 тэрбум төгрөгөөр 7 арга хэмжээ, орон нутгаас 450.0 сая төгрөг, Дундговь аймагт 1.2 тэрбум төгрөгөөр 6 арга хэмжээ, орон нутгаас 360.0 сая төгрөг, Хэнтий аймагт 1.6 тэрбум төгрөгөөр 8 арга хэмжээ, орон нутгаас 480.0 сая төгрөг, Сүхбаатар аймагт 1.0 тэрбум төгрөгөөр 7 арга хэмжээ, орон нутгаас 300.0 сая төгрөг, Дорнод аймагт 1.2 тэрбум төгрөгөөр 9 арга хэмжээ, орон нутгаас 360.0 сая төгрөг буюу орон нутгаас нийтдээ 2,370.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулсан. Нийт 9,070.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2020 онд хийсэн байна.		100
57		6.1.3. Үнэ цэнийн сүлжээний санхүүжилтийн цогц бүтцийг бий болгож, шаардлагатай шатанд хөрөнгө	2014 - 2020	-		"Монголын хаан ширхэгт" ноолуурын олон улсын форум зохион байгуулж, тохирлын баталгаатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүй, чанар аюулгүйн стандартын шаардлага хангасан ээлтэй бүтээгдэхүүн хөгжүүлэх, улмаар олон улсын зах зээлд танигдсан нэр хүндтэй бренд болгох үйл ажиллагааг эхлүүлсэн. Олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлага бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын "Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт"-ыг явуулах эрх бүхий	90	

		оруулалтыг нэмэгдүүлэх;				“Баталгаажуулалтын алба” байгуулсан. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан эскпортод гаргаж эхэлсэн. - "ISO 9001-2015 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо” стандартыг “Мон-Ирээдүй” ХХК арьс шир боловсруулах үйлдвэр, “Бест Шүес” ХХК гутлын үйлдвэр, Дархан Нэхий ХК нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрт нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээ олгосон. - Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлагад тавигдах шаардлагын тухай олон улсын ISO 16128 стандарт, ОУ-ын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүллээ. Үүний үр дүнд олон улсад бүтээгдэхүүнээ гаргах, хөрөнгө оруулалт татах, нэмэгдүүлэх бүрэн боломжтой болсон.	
58		6.1.4. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, үнэ цэнийн сүлжээг тэргүүлэгч аж ахуйн нэгжээр дамжуулан хөгжүүлэх;	2014 - 2020	-		1. Арьс, ширний үйлдвэрийн парк байгуулж, үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, загвар үйлдвэр байгуулахыг дэмжих ажлын хүрээнд: -Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт хариуцсан “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоол, “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлах тухай Засгийн газрын 2020 оны 233 дугаар тогтоолыг тус тус баталсан. - Дэд бүтцийн бүтээн байгуулалтад 165.8 тэрбум төгрөгийн 14 ажил гүйцэтгэхээс 40.9 тэрбум төгрөгийн 5 бүтээн байгуулалтын ажил хийгдсэн. Үүнд: Төслийн бэлтгэл 100%, Арьс ширний үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга 63.4%, тоног төхөөрөмж 30.9%, Цахилгаан түгээх, хангах дэд бүтэц 57.2%, гадна инженерийн шугам сүлжээ /дулааны шугам, цэвэр ус/ 77.4%, нийт дэд бүтцийн бүтээн байгуулалт 22.9%-тай байна. Үйлдвэрийн бүтээн байгуулалтад 392.6 тэрбум төгрөгийн 17 үйлдвэр байгуулагдахаас 10.8 тэрбум төгрөгийн ноос боловсруулах 1, богийн арьс боловсруулах 1 үйлдвэрийн бүтээн байгуулалт хийгдэж, 348.6 тэрбум төгрөгийн 13 үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил хүлээгдэж байна. Бог малын арьс боловсруулах үйлдвэр 8.1%, ноос ноолуур боловсруулах үйлдвэр 31.9%, нийт үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт 1.4%-тай байна. “Ангилж бэлтгэсэн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх загвар туршилт”-ын хүрээнд “Жинст Мөрөн” ХХК нь ангилж бэлтгэсэн бага насны ямааны ноолуурын анхан шатны боловсруулалтыг “Өгөөж Шим” ХХК, ээрэхийг “Сноү Фиилд” ХХК, сүлжихийг “Мөнхбумууд” ХХК-ууд кластераар хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулан “Монголын хаан ширхэгт” бүтээгдэхүүний загвар гарган ажиллаж, Европын холбооны улсад бүтээгдэхүүнээ гаргахаар судалсны үндсэн дээр Герман улсад нэрийн барааны дэлгүүр нээсэн. Цар тахлын улмаас борлуулалт түр зогсоод байна.	100

59	6.1.5. Эрсдлийг бууруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоог цогц байдлаар нэвтрүүлэх;	2014 - 2020			“Тохирлын үнэлгээний байгууллагын хөгжил” ТББ-аар “Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлж, үйлчилгээг хүлээн авсан. Хуулийн төсөлд Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо, Монголын жимс жимсгэний үндэсний холбоо, Мөнх даатгал ХХК-иас ирүүлсэн саналыг төсөлд тусгах ажлыг хийж байна. Мөн ХХААХҮЯ-ны албан ёсны цахим сайт mofa.gov.mn-д тариалангийн даатгалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг байршуулан олон нийтийн санал авч байна. Мөн хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн хэлэлцүүлгийг Тогтвортой хөдөө аж ахуй төсөлтэй 3 үе шаттай хийхээр төлөвлөж, бэлтгэл хангаж байна. Энэхүү хууль батлагдан гарснаар тариалангийн салбарын эрсдлийг бууруулах, үйлдвэрлэлийг тогтворжуулахад бодитой хувь нэмэр болно. 2020 онд туршилтын журмаар тариаланчдыг улаан буудайн индексжүүлсэн даатгалд хамруулахаар ХААДС болон Үндэсний давхар даатгал ХК-тай хамтран ажилласнаар нийтдээ 387 аж ахуйн нэгж, иргэнийг гэрээний дагуу даатгалын хураамжийнхаа урьдчилгаа 30 хувийн төлбөртэйгээр даатгалд хамруулах ажлыг зохион байгууллаа. Энэхүү даатгалд хамрагдсан тариалан эрхлэгчдээс нийт 44 аж ахуйн нэгж, иргэн 316,795,838.90 төгрөгийн нөхөн төлбөр авсан байна. Үүний 42 аж ахуйн нэгж нэмэлт эрсдэл буюу 8, 9 дүгээр сард учрах хяруу, хүйтрэлт, цасны эрсдэлийг сонгон авч даатгуулсан бөгөөд нийт 12 аж ахуйн нэгж, иргэнд 241,304,400 төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор боллоо. Даатгалын арга хэмжээнд Үндэсний давхар даатгал ХК, Мөнх даатгал болон Ард даатгал, SCOR буюу олон улсын давхар даатгалын компани оролцсон.	70
60	6.1.6. Дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нутагшуулах, салбарын судалгаа ба хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих;	2014 - 2020			ХХААХҮ-ийн салбарт 2020 онд нийт 21.4, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 9.4 тэрбум төгрөг, нийт 32.1 тэрбум төгрөгөөр 158 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	90
61	6.1.7. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, төлөвшүүлэх;	2014 - 2020	улсын төсөв -68 сая төгрөг		Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2020 онд мал аж ахуйн хоршоодод арьс шир боловсруулах 1 багц нь 17 сая төгрөг бүхий 4 багц 68 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 5 жилийн хугацаатай түрээсийн нөхцөлөөр олгов. Үүний үр дүнд хаягдаад байсан түүхий эдийн тодорхой хувийг үйлдвэрийн зориулалтаар ашиглах боломж бүрдлээ.	90

62	6.1.8. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг бүс нутаг, ач холбогдол, чанар, бусад хүчин зүйлд суурилан эрэмбэлэн дэмжих;	2014 - 2020			ХХААХҮ-ийн салбарт 2020 онд нийт 21.4 тэрбум төгрөг батлагдаж, төсөл хөтөлбөрөөс 9.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна	70
63	6.1.9. Уул уурхайн татварын орлого, нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа хөгжлийн сан бүрдүүлж, зарцуулах;	2014 - 2020			ХХААХҮ-ийн салбарт өндөр технологи, инновацийг хөгжүүлэх чиглэлээр судалгаа хөгжилд 26.0 сая төгрөгийг зарцуулсан.	70
64	6.1.10. Дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах үйл ажиллагааг дэмжих.	2014 - 2020	улсын төсөв - 204,210.4 сая төг		Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32, Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолоор Монгол Улсын 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, бэлтгэсэн нэг килограмм ноолуур тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгохоор баталж, нэг ямааны ноолуурын гарцыг дунджаар 300 граммаар тооцон 2020 онд 203 641 малчин, мал бүхий этгээдэд 175 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон. 37825 малчны тушаасан 2,610,197 ширхэг арьс ширэн түүхий эдэд 9.9 тэрбум төгрөг, 46,828 малчны тушаасан 13.2 мян.тн ноосонд 19.4 тэрбум төгрөгийн урамшуулал тус тус олгосон. Түүхий эдийн бэлтгэлд ангилал, зэрэглэлийн дагуу ялгавартай үнийг тогтоож, чанарыг үнэлэх систем рүү шилжүүлэхээр Малчдын IQ код, арьс шир, ноос ноолуурын чанартай уялдуулан урамшууллын журамд өөрчлөлт оруулж, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанд оруулахаар ажиллаж байна.	100

65	6.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх:	6.2.1. Дотоодын үйлдвэрлэлийг төрийн дэмжлэг, тарифын болон тарифын бус зохицуулалтаар хамгаалах;	2014 - 2020	-	Цар тахлын онцгой нөхцөл байдалд ажиллаж буй боловсруулах үйлдвэрүүдэд ус, дулаан, цахилгааны хэрэглээг хөнгөлөх чөлөөлөх санал боловсруулж, Засгийн газар, УОК-т хүргүүлж, бүрэн чөлөөлөх, зайлшгүй ажиллах шаардлагатай үйлдвэр аж ахуйн нэгжийн судалгааг гарган, УОК-т хүргүүлэн хөнгөн үйлдвэрийн салбарын 8 чиглэлийн үйлдвэр ААН-ийг ажиллуулах шийдвэр гаргуулсан. Ямааны ноолуур бэлтгэх, боловсруулах худалдаалах, экспортод гаргах үйл ажиллагаанд мөрдөх техникийн зохицуулалтын төслийг ЗГХЭГ-т 2020 оны 01/386 тоот албан бичгээр хүргүүлсэн. 1. Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, элсэн чихэр, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах өвс, бүх төрлийн малын тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаан буудай, улаанбуудайн үр, тослог ургамлын тосыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар яаралтай горимоор хэлэлцүүлэн УИХ-ын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн хуралдаанаар баталсан. 2. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосны жагсаалтыг батлах тухай 2020 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн 214 дүгээр тогтоолоор баталсан. 1. Улаанбуудайн гурил үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгжүүдийг хамгаалах зорилгоор 2020 оны 1 дүгээр сараас импортоор орж ирэх улаанбуудайн гурилыг "баяжуулсан хүнсний тухай хуулиар" зохицуулж байна.	70
66		6.2.2. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх, экспортыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах;	2014 - 2020	-	Дэлхийн банкны санхүүжилтээр ГХЯ-наас Монгол улсын төвийн эдийн засгийн коридорын үнэлгээ хийлгэсэн. Мөн Дэлхийн худалдааны байгууллага /ИТС/-ын санхүүжилтээр “Худалдаа ба хөрөнгө оруулалтын замын зураг” төслөөс Ноос, ноолуурын салбарын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг боловсруулах судалгаа хийсэн. Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр /НҮБХХ/-ийн “Ноолуурын тогтвортой өртгийн сүлжээ” төслийн хүрээнд Монгол улсад байгаль орчинд ээлтэй ноолуур үйлдвэрлэлийн чиглэлээр богино болон дунд хугацаанд авч хэрэгжүүлэх талуудын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлж, Замын зураг боловсруулах ажил гүйцэтгэсэн. 2020 онд гадаад борлуулалтыг дэмжих чиглэлээр 8 сараас зөвлөх ажиллуулж ЕХ үйлдвэрлэгч ба худалдан авагч нартай хамтран ажиллаж байна. Европын холбооны Трам төсөлтэй хамтран сарлагийн хөөвөр боловсруулах чиглэлээр загвар төсөл хэрэгжүүлж байна. Жинст мөрөн, Сноу филдс,	70

					Мөнхбумууд, Бест кашемир, Уужин, Сор кашемир зэрэг үйлдвэрүүд кластерын зарчмаар ажиллах загвар хэрэгжүүлж байгаа бөгөөд Европын зах зээлд бүтээгдэхүүн гаргахаар Герман улсад нэрийн барааны дэлгүүр нээсэн.	
67	6.2.3. Бүс нутгийн болон олон улсын байгууллагад гишүүнээр элсэх;	2014 - 2020			Корона вируст цар тахлын нөлөөгөөр энэ төрлийн ажлыг хойшлуулаад байна.	50
68	6.2.4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэг цонхны бодлогоор явуулах;	2014 - 2020	-		Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлж, ХАА Биржийн үйл ажиллагааг 24/7 горимоор явуулах, ижил төрлийн бусад биржүүдтэй мэдээлэл солилцох зорилгоор Блокчейн технологид суурилсан арилжааны платформ систем нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн иргэд, арилжаанд оролцогчдыг мэдээллээр хангах зорилгоор order.msc.mn захиалгын платформ нэвтрүүлсэн. Ингэснээр зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг хангах, зах зээлийн үнийн хэлбэлзлийг багасгах, малчид, хоршоодын орлогыг нэмэгдүүлэх гэх мэт олон давуу тал бий болсон. БНХАУ руу экспортлох мах, махан бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, дайвар бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, зөгийн балны экспортын эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, эрсдэлийн үнэлгээний ажлыг эхлүүлэхтэй холбоотой яриа, хэлэлцээг ГХЯ-аар дамжуулан “нэг цонхны зарчим”-аар хэрэгжүүлж байна.	70
69	6.2.5. Хөдөө аж ахуйн чөлөөт бүсийг байгуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, алслагдсан бүс нутагт экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих;	2014 - 2020			Ховд аймагт баруун бүсийн аймгуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварыг бий болгож дэвшилтэт техник технологи бүхий 16-18 үйлдвэр бүхий малын гаралтай түүхий эд, арьс шир ноос ноолуур боловсруулан, дотоодын хэрэгцээнд болон экспортод гаргах бүтээгдэхүүн үйлдвэрлэх "Шинэ ховд" УТП-ыг байгуулахаар ажиллаж байна. Нийт 3 сая ш арьс, 3 мянган тонн ноос, 300 тонн ноолуур, 3400 тоо хаягдал яс, 440,0 мянган гогцоо өлөн гэдэс боловсруулах хүчин чадалтай. 2020 оны эцсийн байдлаар дэд бүтцийн бүтээн байгуулалт 90 хувьтай байна. “Хөх сарлагийн хөөврийн ангилал”-ын загвар туршилтыг Хөвсгөл аймагт хэрэгжүүлэн, Улаан-Уул сумын хоршооноос 230 малчин өрх, Арбулаг сумаас 71, Алаг-Эрдэнэ сумаас 442 буюу нийт 743 гишүүн малчин өрх хамтран ажилласны дүнд нийт 5 тонн гаруй хөөвөр бэлтгэснээс 1,5 тонн хөх сарлагийн хөөврийг “Жинст Мөрөн” ХХК нь өнгөөр нь тусгайлан ангилан бэлтгэж, түүхий эдийн худалдан авалт, анхан шатны тордолт,	70

					хадгалах агуулах, тээвэрлэлт болон шаардагдах зардлыг хариуцан ажилласан. “Бага насны ямааны ноолуурын ангилалт”-ын загвар туршилтад Улаан-уул сум хоршооноос 45 малчин өрх, Арбулаг сумаас 48, Алаг-эрдэнэ сумаас 25 буюу нийт 118 өрх хамрагдаж, ямааны ноолуурыг насаар ангилан ялгаж бэлтгээд хоршоогоор дамжуулан 3 тонн гаруй бага насны ноолуурыг бэлтгэн “Жинст Мөрөн” ХХК компанитай хийсэн гэрээний хүрээнд нийлүүлжээ.	
70	6.2.6. Мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний стандартыг шинэчлэх, нутагшуулах, тэдгээрийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах тогтолцоонд шилжүүлэх;	2014 - 2020			Арьс ширэн түүхий эдийн нядалгааны үеийн бэлтгэл, чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд Малын арьс ширийг өвчих, хуулахад тавих ерөнхий шаардлага MNS 6870:2020 стандарт батлагдав. 1. Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумын салбар хариуцсан мэргэжилтнийг цахим сургалтад хамруулсан. 2. “Түүхий эдэд тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт”-ыг Архангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар аймаг, Нийслэлд мал нядалгааны цех, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгч, малчдад сургалт явуулав. 3. “Хонины ноосны чанарыг сайжруулах” олон улсын сургалтыг Дундговь аймагт зохион байгуулж, Хөвсгөл, Төв, Ховд, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Сүхбаатар аймгийн сумдын хоршооны 40 гаруй гишүүн хамрагдаж хяргагч, ноос ангилан ялгагчаар бэлтгэгдэв. Ноос хяргах төхөөрөмжийг хоршоодод хүлээлгэн өгөв. 4. Арьс ширний нядалгааны үеийн гэмтлийг бууруулах зорилготой арьс шир хуулах төхөөрөмж дээр ажиллах практик сургалтыг Ховд, Баянхонгор аймагт зохион байгуулав.	90
71	6.2.7. Хөдөө аж ахуйн гаралтай газар зүйн заалттай, органик, брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих;	2014 - 2020			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-09 дүгээр тушаалаар батлагдсан “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”, А-180 дугаар тушаалаар батлагдсан “Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын дагуу органик хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn–г ашиглалтад оруулсан. 2020 оны 12 сарын байдлаар Органик хүнсний бүртгэл, мэдээллийн www.organic.gov.mn цахим санд бүртгэлтэй, эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан дотоодын үйлдвэрийн 382 органик, шилжилтийн үеийн 238, импортын 25 органик хүнсийг зах зээлд нийлүүлсэн байна.	70
72	6.2.8. Гадаад оронтой байгуулсан мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хэлэлцээрийн	2014 - 2020			Гадаад оронтой мал эмнэлэг, ургамал хорио цээрийн хэлэлцээр шинээр байгуулж байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэх ажлын хүрээнд дараах улс орнуудтай хамтран ажиллах хэлэлцээр, санамж бичиг, гэрчилгээний төслийг ХХААХҮЯ болон ГХЯ-аар дамжуулан хүргүүлэв. Үүнд: 1. БНПУ-ын мал эмнэлгийн газартай мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах санамж бичиг 2. БНКУ-ын Мал эмнэлэг, ургамал хорио	90

		нөхцөлийг сайжруулах, шинэчлэх, шинээр байгуулах.				цээрийн улсын хяналтын албатай мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр 3. ОХУ-ын Мал эмнэлэг, ургамал хорио цээрийн хяналтын Холбооны албатай мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах санамж бичиг. 4.Саудын Арабын вант улсын Байгаль орчин, ус, хөдөө аж ахуйн яамны малын эрсдийг үнэлэх газартай мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах хэлэлцээр. 5. Исламын Бүгд Найрамдах Иран Улсын тахианы мах импортлох олон улсыг гэрчилгээ. 6. Бүгд Найрамдах Азербайжан Улсын Хүнсний аюулгүй байдлын агентлагтай мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр. 7. ОХУ-ын Буриад Улсын Мал эмнэлгийн газартай Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газар хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.	
ЗОРИЛТ 6.2							77.56
73	7.1. Хүний нөөц	7.1.1. Ажиллагсдын ахуй амьдралаа сайжруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах, үйлдвэрлэлээ өргөтгөх, хорших санаачилгыг дэмжих, таатай нөхцөлийг бүрдүүлэх;	2014 - 2020			Хөдөө Амьдарья ТББ, Хутаг-Өндөр сумын Иргэдийн хурал, ЗДТГ, Хутаг-Өндөр сумын Баялаг бүтээгчдийн холбоо, Үхрийн аж ахуй эрхлэгчдийн зохицуулах зөвлөл, Бялхам Үндэс ТББ, бизнес эрхлэгчид болон орон нутгийн иргэд хамтран 2020 онд “Хөдөө Амьдарья I – Хутаг-Өндөр 2020” арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээгээр шилжилт хөдөлгөөнийг дэмжих бодлогын хэлэлцүүлэг, эдийн засгийн түншлэлийг хөгжүүлэх семинар, нийгмийн болон бизнесийн аялал, ажлын байрны үзэсгэлэн, мал аж ахуйн мэргэжил танилцуулах өдөрлөгийн хүрээнд зохион байгуулж арга хэмжээний үр дүнд орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сэдэлжүүлэх, Хутаг-Өндөр сумыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг дэмжиж, нийгмийн бүлгүүдийг харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд чиглүүлэх, эдийн засгийн түншлэлийг хөгжүүлэх зорилгоор нутгийн онцлог бүхий үхрийн кластерийн системийг санал болгож, арга зүйн туслалцаа үзүүлэх, чадавхижуулах хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх, шинээр шилжин суурьшсан, шилжин суурьшихаар төлөвлөж буй иргэдэд тулгамдаж буй газар төлөвлөлт, газар өмчлөл, суурьшилт, дэд бүтэц зэрэг асуудлыг нутгийн захиргаатай хамтран шийдвэрлэхэд туслэх зорилгоор төр хувийн хэвшлийн хэлцлийг зохион байгуулж, үүссэн санал санаачлагыг дэмжих, шинээр шилжин суурьших иргэдийн үл хөдлөх хөрөнгө болон бизнесийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломж бүрдлээ.	70

74	7.1.2. Малчин, мал зүйч, зохиомол хээлтүүлгийн техникч, малын эмчийн хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамааруулах, гэрээт ажилчид, малчдын нийгмийн хамгааллын баталгааг ажил олгогчоор хангуулах;	2014 - 2020	-		<p>1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт 12143 малчин хамрагдаж, 6749 ажлын байр бий болж 19.7 тэрбум төгрөг зарцуулсан, хэрэгжилт дунджаар 93 хувьтай. Малжуулах арга хэмжээнд 1073 малчин өрхийн 2708 малчин иргэн хамрагдаж 30471 хонь, 38251 ямаа 1329 үхэр 53 адуу худалдан авахад 4.9 тэрбум төгрөг, малчдыг мэдлэгжүүлэх болон залуу халааг бэлтгэхэд чиглэгдсэн мал маллах арга ажиллагааны сургалт, туршлага солилцох уулзалтад 1842 өрхийн 2894 малчин иргэн хамрагдаж 889.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p> <p>2. Засгийн газрын 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол малчин” үндэсний хөтөлбөр болон Хөдөлмөр халамж үйлчилгээний Ерөнхий газраас зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл хэрэгжүүлсэн. Хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй гэр бүл болон туслах малчинг цалин хөлстэй ажилд зуучилж, тогтвортой ажлын байр, орлоготой болгоход чиглэгдсэн бөгөөд нийт 627 иргэн хамрагдаж 108 сая төгрөг зарцуулж 547 ажлын байр бий болсон байна.</p> <p>2. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавх нэмэгдүүлэх нь” төсөл 2020.07-2021.12 сар хүртэлх хугацаанд Завхан аймгийн Их-Уул, Тэс, Отгон, Дөрвөлжин, Идэр суманд хэрэгжиж байна.</p> <p>3. Мал зүйч, зохиомол хээлтүүлгийн техникч, малын эмчийн хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамруулах зорилгоор суурь судалгаа гаргаж, ХНХЯ-нд хамтран ажиллах санал хүргүүлсэн бөгөөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөр ажлын байрны нөхцөлийн үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.</p>	70
75	7.1.3. Малчин, мал бүхий этгээдийн өмч хөрөнгийг сайн дурын болон албан журмын даатгалд даатгуулах хүрээг нэмэгдүүлж болзошгүй эрсдлээс хамгаалах;	2014 - 2020	-		<p>2020 онд 51,3 мянган малчин сайн дурын нийгмийн даатгалд хамрагдсан. Мөн 21 аймгийн 18.3 мянган малчин өрхийн 5,193.0 сая толгой малыг малын эрсдэлийн даатгалд хамруулсан.</p> <p>Малын индексжүүлсэн даатгалд 33,894 малчин өрхийг хамруулж, 4,0 тэрбум гаруй төгрөгийн хураамжийн орлого төвлөрсөн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 23.1 хувийг эзэлж байна.</p>	90
76	7.1.4. Малчид, тариаланчдын ая тухтай амьдрах, тогтвортой ажиллах нөхцөлийг сайжруулах, малчин эмэгтэйчүүд, залуу	2014 - 2020	-		<p>1. Мал аж ахуйн салбар, малчдыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн урт, дунд хугацааны бодлого, нийгэм, эдийн засгийн шаардлага, эрэлт хэрэгцээнд суурилж, ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-172 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн гишүүд, салбарын эрдэмтэн судлаачид, мал аж ахуйн салбарын судалгааны төрийн бус байгууллага, орон нутгийн мэргэжлийн байгууллага, малчдын төлөөлөл хамтарч боловсруулан “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийн төслийг Засгийн</p>	70

		малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх;			газрын 2020 оны хуралдаанаар хэлэлцэн баталснаар үндсэн 5 зорилтын хүрээнд 2020-2024 оны хугацаанд хэрэгжүүлнэ. 2. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь малгүй болон цөөн малтай 18-45 насны өрхийг малжуулах, аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хамруулах, туршлага солилцох уулзалт, нэгдсэн өдөрлөг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд 2020 оны эцсийн байдлаар 5400 гаруй өрхийг хамруулж, 10.8 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан байна. 3."Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай" хуулийг хэрэгжүүлснээр 2020 оны байдлаар нийт 628.1 мянган малчин, үүнээс 138.0 мянган малчин хамрагдаж 11 хүртэл жил ажилласнаар нөхөн тооцуулсан.	
77		7.1.5. Агрономич, механикжуулагч, инженер техникийн ажилтныг тариалангийн аж ахуйн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан бэлтгэх, сургалтын орчныг сайжруулах, сургалтын агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагыг сургалттай хослуулахад чиглүүлэх;	2014 - 2020		Монгол ногоо, Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн хүрээнд "Хүнсний ногооны үр үйлдвэрлэл, талбайн хянан баталгаа хийх, агротехнологи" сэдэвт сургалтыг талбайд болон танхимд Увс, Сэлэнгэ, Дархан-уул, Төв аймгийн Борнуур сумдад зохион байгуулав. Төслийн 12 аймгийн 200 гаруй ногоочин, ХААИС-ийн багш, Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн эрдэмтэд, АХБ-ны Олон улсын зөвлөх багш, Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо ТББ, Хөдөөгийн хөгжил туслалцааны нийгэмлэг ТББ оролцов.	50
78		7.1.6. Салбарын мэргэжилтэн, инженер техникийн болон бусад мэргэжилтэй ажилтны төгсөлтийн дараах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах зайн сургалтын	2014 - 2020	-	1. ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилд тусгай дунд мэргэжлийн хүмүүст мал зүйчид бакалаврын боловсрол олгох 1.5 жил буюу хавсарга хөтөлбөрийн сургалтад 17 хүн хамрагдаж, мал зүйчийн диплом авсан. Мөн 2019-2020 оны хичээлийн жилд мал зүйч бакалаврын боловсрол олгох эчнээ 2.5 жилийн сургалтад 21 хүн хамрагдаж байна. 2. “Бог малын ангилагч, шинжээч бэлтгэх” сургалтаар 9 аймаг, нийслэлийн 28 мал зүйч хамрагдаж бог малын ангилагч, шинжээч мэргэжлийн үнэмлэх авсан. 3. Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг Малын удмын сангийн үндэсний төв холбогдох мэргэжлийн	100

		тогтолцоог хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, мэргэшлийн зэрэг олгох;			байгууллагатай хамтран зохион байгуулж, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв зэрэг 8 аймгийн 16 сумын 20 мал зүйч, 10 малын эмч, 10 фермер эрхлэгч нийт 46 мэргэжилтэн хамрагдаж мэргэжлийн үнэмлэх сертификат авсан. 4. ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны А-386 дугаар тушаалаар 11 мал зүйчид "Зөвлөх мал зүйч", 3 мал зүйчид "Тэргүүлэх мал зүйч" мэргэжлийн зэрэг олгов. 5. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-323 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журам”, 2020 оны А-385 дугаар тушаалын хавсралтаар “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ыг тус тус баталсан. ШХА-ийн Ногоон алт малын эрүүл мэнд төсөлтэй хамтран 180 хүний суудалтай видео хурлын тоног төхөөрөмж, өргөн нэвтрүүлгийн систем, акустик систем, ухаалаг дэлгэц, багтаамжтай компьютер, хэвлэх төхөөрөмжөөр тоноглогдсон зайн сургалтын ухаалаг танхим Хөдөө аж ахуйн сургууль дээр шинээр байгуулав. Хөдөө аж ахуйн их сургууль, НҮБ-ын ХХААБ-тай хамтран Мал эмнэлгийн цахим сургалтын системийг хөгжүүлж, туршиж байна. Мөн 21 аймаг, нийслэлийн сум, дүүргийн эмч мэргэжилтнүүдэд зайн сургалт явуулах 500 хэрэглэгч хандах боломж бүхий цахим сургалтын төвтэй боллоо.	
79		7.1.7. Малчид, тариаланчдад үйлдвэрлэл, технологи, бизнес, байгаль, цаг уурын өөрчлөлтийн талаар зохистой мэдлэг олгох сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу мэдээллийн болон бусад хэрэгслийг ашиглан тасралтгүй явуулах;	2014 - 2020	-	1. Мэргэжлийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн хүрээнд малчдад мал маллагааны арга туршлага эзэмшүүлэх, аж ахуй эрхлэх арга ажиллагаанд сургах, бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулах, ургамал хамгаалах, тэжээл бэлтгэх, эрчимжсэн аж ахуй болон жижиг, өрхийн үйлдвэрлэл эрхлэх, мал үржүүлэх, мал эмчлэн сэргийлэх чиглэлээр 2020 оны байдлаар 125 сум, дүүрэгт давхардсан тоогоор 720 гаруй тэнхмийн болон цахим сургалт зохион байгуулж 56.3 мянган малчин хамруулав. 2.Тогтвортой ноос, ноолуурын эвсэл, Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвтэй хамтран "Малчин мэргэжлийн ажил мэргэжлийн" стандарт батлуулж, сургалтын хөтөлбөр боловсруулан, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 5 төвтэй хамтран 125 малчинд сургалт зохион байгуулсан. Мэргэшсэн 12 багшаар дамжуулан ноолуур бэлтгэн нийлүүлэгч 1500 эмэгтэйд сургалт явуулсан байна. 3.“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтээр Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Дундговь, Архангай, Говь-Алтай, Хөвсгөл, Булган зэрэг төслийн зорилтот аймгийн бага, дунд орлоготой иргэдийн орлогыг бодитоор нэмэгдүүлэн тэдгээрийн амьжиргааг тогтвортой болгох зорилгоор Үндэсний холбоо гишүүн хоршооддоо чадавхын үнэлгээ хийх, 4Р бизнес төлөвлөгөө боловсруулах ажлыг 9 аймгийн 25 суманд зохион байгуулсан.	90

					<p>4. Дундговь аймгийн ЗДТГ, НҮБ-ын хамтын ажиллагааны хүрээнд “Хонины ноосны чанарыг сайжруулах” олон улсын сургалтыг Сайнцагаан суманд зохион байгуулав.</p> <p>5. Улсын хэмжээнд 5 аймагт МСҮТ дээр малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийн дагуу шат дараалсан сургалт зохион байгуулж байна. Анхан болон ахисан түвшний сургалтад нийт 1200 гаруй малчин хамрагдсан байна.</p> <p>6. Малчин лавлах-109 төв, монгол малчин сэтгүүлийг улирал тутам гаргаж 21 аймгийн 330 суманд захиалгаар түгээж байна. Мөн малчин телевизтэй хамтран малчдыг соён гэгээрүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэвтрүүлэг, мэдээ нэвтрүүлэж байна.</p>	
80	7.1. Хүний нөөц	7.1.8. Нүүдлийн соёл, иргэншил, уламжлалд суурилсан аялал, жуулчлалыг малчдын ахуй амьдралд түшиглэн хөгжүүлэх.	2014 - 2020		<p>УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Малчдын ахуй амьдралд түшиглэн нүүдлийн соёл, иргэншил, уламжлал бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, орлого, ашгийг өсгөх зорилт дэвшүүлсэн. “Сайханы сарлаг”, “Ингэний айрагны баяр”, “Говь фестиваль”, “Адуучин тэмцээн”, “Мөсний баяр”, “Цааны баяр” зэрэг арга хэмжээг орон нутагт жил бүр уламжлал болгон малчдын ахуй амьдралд түшиглэн хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж аялал жуулчлалыг татах, мал аж ахуй болон газар тариалан, гар урлалын бүтээгдэхүүнээ зарж борлуулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ болж хэвшиж байна.</p>	50
ЗОРИЛТ 7.1						73.75
ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО						77.76